

7

ИНФЛЯЦ

М. Женис

Макро эдийн засгийн тогтворгүй байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг бол инфляц юм.

Эдийн засгийн ухааны нэрт эрдэмтэн М. Фридман "Хэрэв улс төрчид инфляцийн эсрэг ямар нэгэн арга хэмжээ авч эхлэх юм бол тэр даруй сөрөг үр дагаврыг мэдрэх болно. Хүүгийн хувь өснө. Мөнгө ховор хомс болно. Энэ бүхэлдээ таатай биш байдаг.

..."Инфляцийг хурцдуулахгүй байх хамгийн их бэрхшээл нь тодорхой хугацаа өнгөрсний дараа илааршуулж эдгэрэхээсээ илүү өвчин эмгэгтэйгээ эвлэрэхэд хүргэдэгт оршино. Хэрэв эмчилгээ үйлчилж эхэлвэл эдийн засгийн өсөлт, үнийн тогтвортой байдлын аль нэгэнд хүрэхийг хүмүүс мэддэггүй..." гэжээ.

Инфляцийн талаар өөр хоорондоо ялгаатай янз бүрийн үзэл бодол байдаг. Ихэнх эдийн засагчдын хүлээн зөвшөөрдөг тодорхойлолт нь:

Мөнгөний худалдан авах чадвар буурч, улмаар үнийн түвшин мэдэгдэхүйц хэмжээгээр үргэлжилсэн байдлаар өсөх явдлыг инфляци гэдэг.

Улс орны хэмжээнд хүнсний болон өргөн хэрэглээний барааны үнэ өсөн, цалин хөлс хоорондын зөрүү хэмжээ ихсэж, ард түмний амьжиргааны түвшин эрс доройтож эхэлснээр инфляц хурц шинж төрөхөө олдог. 1991 оны 1 дүгээр сард Засгийн газрын 20 дугаар тогтоол гарч мөнгөний масштабыг 2 дахин өөрчилснөөс хойш үнэ тасралтгүй түргэсэх хурдтайгаар өсч ирсэн бөгөөд 1992 онд үнийн нийт өсөлт 325% болж, Монгол улс дэлхийн хамгийн өндөр инфляцтай арван орны нэгэнд орж байв.

Энэ үеэр хүн амын амжиргааны баталгаажих доод түвшин хотод 990, хөдөөд 650 төгрөг, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 8 төг 46 мөнгөөр тогтоож байсан нь олон түмнийг зөвхөн тайвшруулах л арга хэмжээ болж байлаа.

Олон улсын практикт инфляцийг хэрэглээний үнийн индекс, үйлдвэрлэгчийн бөөний үнийн индекс, үндэсний нийт бүтээгдэхүүний дефлятороор тус тус тооцдог ба эхний арга нь түгээмэл хэрэглэгддэг юм.

Инфляцийг хурдцаар нь тайван (жилд 10% хүртэл), өндөр (200% хүртэл), түүнээс дээш бол хэт өндөр буюу гиперинфляци гэж ангилдаг. Энэ хэлбэрүүдийн нийгэмд үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй. Тухайлбал, түргэн хурдацтай инфляцийн үед ирээдүйд түүний түвшин ямар байхыг таамаглахад бэрхшээлтэй байдгаас шалтгаалан гэрээ хэлцэл байгуулах, урт хугацааны зээл олгох хөрөнгө оруулалт хийх нь тун эрсдэлтэй болж аж ахуйн үйл ажиллагааны идэвхжилт эрс сулран үйлдвэрлэл үйлчилгээний цар хүрээ цөөрч, багасахад хүргэдэг. Мөн хүмүүст юмны үнэ улам нэмэгдэнэ гэсэн болгоомж бий болж хямдхан дээр нь ахиухан авч нөөцлөх хандлага бий болон эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг алдагдуулж, инфляцийг улам хурдасгах аюултай.

М.Бруно, В.Эстерли нар дэлхийн 127 орны 1960-1992 оны эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдийг судлажээ. Тэд дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 2.6%, түүнээс дээш байхын тулд жилийн инфляцийн түвшин 5%-аас хэтрэхгүй байх ёстой. Мөн инфляцийн түвшин жилийн 1000 хувиас давах нөхцөлд үйлдвэрлэлийн уналт 6-7 хувиас ч илүү унана гэж дүгнэсэн бөгөөд үйлдвэрлэлийн өсөлтөд нөлөөлөхгүй байхын тулд инфляци 40%-иас хэтрэхгүй байх ёстой гэжээ.

М.Бруно, В.Эстерли нарын аргачлалын дагуу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжиж байгаа шилжилтийн эдийн засаг бүхий орнуудад хийсэн судалгаагаар инфляцийн жилийн түвшин 50%-иас хэтрэхгүй тохиолдолд үйлдвэрлэлийн өсөлт гарах боломжтой байна (Хүснэгт 1).


Хүснэгтээс үзвэл зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих явцад бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийг чөлөөлөх үйл явцыг удаашруулсан орнуудад инфляцийн түвшин харьцангуй өндөр байна. Тухайлбал, 1991-1994 онуудад хэрэглээний үнийн индекс Орос оронд 1545 дахин, Украинд 20933 дахин, Белорусст 6381 дахин, Казахстанд 10047 дахин өсчээ. Инфляцийг үүссэн шалтгаанаар нь эрэлтийн ба зардлын гэж хувааж үздэг.

Шилжилтийн эдийн засаг бүхий орнуудын 1989-1994 оны инфляцийн түвшин, ДНБ-ий үйлдвэрлэлийн өөрчлөлт (өмнөх онтой харьцуулсан хувь)

	1989	1990	1991	1992	1993	1994
Монгол ДНБ	4.2	-2.5	-9.2	-9.5	-3	2.3
Инфляци			54.4	325	183	66.3
Польш ДНБ	0.2	-11.5	-7.6	2.6	3.8	4.5
Инфляци	251	586	70.3	43	35.3	30
Чех ДНБ	0.4	-3	-10	-5	-0.3	1.5
Инфляци	1	10	45.7	8.5	20.8	9
Орос ДНБ	1.5	-3.6	-12.9	-18.5	-12	-12
Инфляци	6	6	92.7	1353	915	336
Украйн ДНБ	4.1	-3.6	-11.9	-17	-14.2	-25
Инфляци	2	4	91.2	1210	4735	1000
Белорус ДНБ	7.9	-3.2	-1.9	-9.6	-11.7	-17.1
Инфляци	1.7	4.5	83.5	969	1188	1621
казахстан ДНБ	-0.3	-0.8	-13	-14	-12	-6
Инфляци	1	4.2	91	1381	1571	1680
Албани ДНБ	9.8	-10	-27.7	-9.7	11	8
Инфляци	1	1	35.5	222.9	85	28
Унгар ДНБ	0.7	-3.5	-11.9	-4.5	-2	1
Инфляци	17	29	34.2	22.9	25.5	19
Румын ДНБ	-5.8	-5.6	-15.1	-13.5	0.7	3.8
Инфляци	1	4	161.1	210.3	256	156
Болгар ДНБ	-1.9	-9.1	-11.7	-5.6	-4.2	-2
Инфляци	6	22	333.5	82	72.8	89

Бараа таваарын эрэлт хэрэгцээ үйлдвэрлэлийн хэмжээнээс давж, тодорхой хэмжээний хомсдол үүснээр юмны үнэ өссөн тохиолдлыг эрэлтийн инфляци, түүхий эд, эрчим хүч, цалингийн зардал нэмэгдснээр нэгж бүтээгдэхүүнд ногдох үйлдвэрлэлийн зардал өсч, улмаар бүтээгдэхүүний үнэ өсөх явдлыг зардлын инфляци гэдэг. Үүнийг дотор нь цалингийн өсөлтөөс, нийлүүлэлтийн механизм зөрчигдсөнөөс шалтгаалсан инфляци гэж ангилдаг. Манай орны хувьд зардлынх нь давамгайлах хандлагатай байдаг.

Инфляцийн жилийн дундаж өсөлт (хувиар) Монгол улс



Шилжилтийн эхний жилүүдэд инфляцийн хэмжээ өндөр байгаа шалтгаан бол зээлийг ямар ч хяналт баталгаагүйгээр их хэмжээгээр олгож байсан ба түүний улмаас хүмүүсийн гар дээрх бэлэн мөнгөний хэмжээ хурдан өсч, банкны систем гүнзгий хямралд өртөв. Мөн үндэсний үйлдвэрлэлийн хэмжээ буурч, чөлөөт валютаар, импортоор авсан өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг дотоодын өндөр үнээр борлуулж байсан. Сүүлийн жилүүдэд нийлүүлэлтээс үүдэлтэй инфляци үйлдвэрлэл, ахуйн суурь бүтээгдэхүүн болох нефть, эрчим хүчний тасалдал, хомсдолоос шалтгаалж байна. Эдгээр бүтээгдэхүүн хэрэглэгддэггүй тэдгээрийн өртөг зардал шингэдэггүй үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүн гэж байдаггүй. Иймээс ялангуяа бензин шатахууны байнгын хомсдол, үнийн өөрчлөлт нь дотоодын өртөг зардалд ихээхэн нөлөөлдөг учир үүнийг арилгаж багасгах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь чухал юм. Инфляцийн түвшин мөнгөний нийлүүлэлтийн өсөлттэй шууд холбоотой гэж үздэг.

ЭДИЙН ЗАСАГ: онол, практик

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998
Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт %/	76.0	31.6	228	79.5	32.9	25.8	32.4	-0.9
Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт бууралт %/	-9.2	-9.5	-3.0	2.3	6.4	2.4	3.3	3.5
Хэрэглээний барааны үнийн өөрчлөлт %/	52.7	325.5	183.0	66.3	53.1	53.2	17.5	6.0

Энэ зүй тогтол манай эдийн засагт мөн тохирдог ба зарим тохиолдолд зөрөх явдал байсан. Тухайлбал, 1991 онд мөнгөний нийлүүлэлт нэмэгдснээр үйлдвэрлэл, орлого буурч инфляци өссөн байхад дараагийн онд мөнгөний нийлүүлэлт өмнөх оныхоос буурсан ч хэрэглээний барааны үнэ их хэмжээгээр өссөн байна. Энэ оны 5-р сард хэрэглээний барааны үнийн индекс өмнөх сарынхаас 3.4%, сүүлийн 12 сарын байдлаар 15.5 хувьд хүрчээ. Үүнд мах, махан бүтээгдэхүүний үнэ, түүний нийлүүлэлтээс хамааран инфляцийн өсөлтөнд дангаар нөлөөлөв. Иймээс манай орны хувьд инфляцийг зохих түвшинд байлгахад бараа бүтээгдэхүүн, ялангуяа өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг тасралтгүй хангах явдал чухал нөлөөтэй. Инфляци бууран зохих түвшинд байх нь гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх урьдчилсан нөхцөл юм. Хөрөнгө оруулалт нэмэгдснээр ажлын байр нэмэгдэж улмаар иргэдийн амжиргааны түвшин дээшлэн эдийн засагт эерэгээр нөлөөлөхөд чухал ач холбогдолтой.